

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ**

**БАРАА ХУДАЛДАН АВАХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер                   *Барилгын их засвар*  
шалгаруулалтын  
нэр:

Тендер                   *БЗДЭМТ/202301010*  
шалгаруулалтын  
дугаар:

## **САНАМЖ**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгөөс дээш, хуулийн 5.1.11-д заасан барилга байгууламжийн ажил, тоног төхөөрөмжийн угсралт, сууринуулалт, туршилт тохируулгын ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа нийлүүлэлтийн тендер шалгаруулалт зохион байгуулахад энэ жишиг баримт бичгийг баримтална.

Энэхүү тендерийн жишиг баримт бичгийн дагуу гэрээ шууд байгуулах аргаар тендер шалгаруулалт зохион байгуулж, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.2-т заасны дагуу хэлэлцээ хийж, гэрээ байгуулах эрх олгоно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.1-д заасны дагуу бүх тендерээс татгалзсан тохиолдолд хуулийн 30.4-ийг үндэслэн тендерийн баримт бичигт шаардлагатай өөрчлөлтийг оруулж, тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулна.

Энэхүү тендерийн жишиг баримт бичгийн санамж болон бүлэг, зүйлийн оноосон нэр нь зөвхөн уг баримт бичгийг ойлгоход хялбар болгох зорилготой.

### **I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)**

Нэгдүгээр бүлэгт заасан тендер шалгаруулалтын зааварчилгаанд өөрчлөлт оруулахгүйгээр хэрэглэнэ.

### **II БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)**

Захиалагч нь тендерт оролцогч болон тендерт тавих шалгуур үзүүлэлт, мэдээллийг хоёрдуугаар бүлэг дэх тендерийн өгөгдлийн хүснэгтэд тусгана. Тендер шалгаруулалтын зааварчилгааны холбогдох зүйл, заалттай уялдуулан хаалт дотор налуугаар бичсэн зааварт нийцүүлэн тохирох мэдээллийг тусгаж тендерийн өгөгдлийн хүснэгтийг боловсруулна.

### **III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА**

Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд захиалагчийн зураг төсөл (техникийн болон ажлын зураг, өртийн төсөв), ажлын хуваарь, тоног төхөөрөмж нийлүүлж, сууринуулан, уг барилга байгууламжийг ашиглалтад бэлэн болгохтой холбоотой ажил, бараа, үйлчилгээнд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолтыг энэ бүлэгт тусгана.

Error! Reference source not found.

Энэ бүлэгт тендерийг үнэлэхэд харгалзах бусад шалгуур үзүүлэлтийг тусгана.

### **V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МЯЯГТУУД**

Тавдугаар бүлэгт тендерт оролцогч тендер бэлтгэхэд шаардлагатай жишиг маягтууд багтана. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд үндэслэн жишиг маягтуудын хаалт дотор налуугаар бичсэн зааварт нийцүүлэн тохирох мэдээллийг бүрэн, үнэн зөв бөглөж ирүүлнэ.

### **VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ**

Зургаадугаар бүлэгт заасан гэрээний нөхцөл нь гэрээний ерөнхий нөхцөл, гэрээний тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маят, гэрээний хавсралт маягтаас бүрдэнэ. Гэрээний ерөнхий нөхцөлд өөрчлөлт оруулахгүйгээр хэрэглэх ба өөрчлөлт оруулах шаардлагатай бол гэрээний тусгай нөхцөлд өөрчлөлтийг тусгана. Захиалагч гэрээ байгуулах эрх олгосон оролцогч болон түүний ирүүлсэн тендерийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад тусгаж, гэрээ байгуулна

# I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

## ГАРЧИГ

A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ .....	5
1. Тендерийн цар хүрээ .....	5
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг .....	5
3. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх .....	5
4. Тендерт оролцогч .....	5
5. Туслан гүйцэтгүүлэх болон түншлэлийн гэрээ .....	6
6. Тендерт оролцогч нэг тендер ирүүлэх .....	7
B. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА .....	7
7. Тендерийн баримт бичиг .....	7
8. Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах .....	7
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт .....	8
10. Тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах, тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгах .....	8
B. ТЕНДЕР БЭЛТГЭХ .....	8
11. Тендер шалгаруулалтад оролцох зардал .....	8
12. Тендерийн баримт бичиг болон тендерийн хэл .....	9
13. Тендерийн иж бүрдэл .....	9
14. Тендерийн жишиг маягтууд .....	10
15. Хувилбарт санал .....	10
16. Ерөнхий нөхцөлийг магадлахад шаардлагатай баримт бичиг .....	10
17. Гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхыг магадлахад шаардлагатай баримт бичиг .....	11
18. Санал болгож буй ажил тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг .....	13
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт .....	13
20. Тендерийн валют .....	14
21. Тендер хүчинтэй байх хугацаа .....	14
22. Тендерийн баталгаа .....	14
G. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ .....	16
23. Тендер баталгаажуулах, илгээх .....	16
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа .....	17
25. Тендерт өөрчлөлт оруулах, тендерийг буцааж авах .....	17
26. Тендер нээх .....	17
D. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ .....	18
27. Нууцлах .....	18
28. Тендерийн талаар тайлбар, тодруулга авах .....	18
29. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх .....	18
30. Тендерийг үнэлэх .....	20
31. Нэг валютад хөрвүүлэх .....	20
32. Арифметик алдааг залруулах .....	20
33. Тендерт оролцогчид давуу эрх олгох .....	21
34. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох .....	21
35. Тендерийг харьцуулах, хэлэлцээ хийх .....	22
36. Тендерт оролцогчийн чадавхыг дахин магадлах .....	22

E. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ .....	23
37. Мэдэгдэл хүргүүлэх .....	23
38. Гэрээ байгуулах эрх олгох .....	23
39. Гүйцэтгэлийн баталгаа .....	24
40. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах .....	24
Ё. БУСАД .....	25
41. Урьдчилгаа төлбөр .....	25
42. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол .....	25
43. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулах тендер шалгаруулалт .....	25
44. Тендер шалгаруулалтын мэдээллийг нийтлэх .....	26

# I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

## A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- |  |   |
|--|---|
| <b>1. Тендерийн цар хүрээ</b>                        | <p>1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу тендерийн өгөгдлийн хүснэгт (цаашид “ТӨХ” гэх)-д заасан захиалагч тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг ТӨХ-д заана.</p> <p>1.2. Захиалагч III бүлэгт тодорхойлсон барилга байгууламжийн ажил, тоног төхөөрөмжийн угсралт, сууринуулалт, туршилт тохируулгын ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа нийлүүлэх тендер шалгаруулалт (цаашид “ажил” гэх)-ыг зохион байгуулна.</p> <p>1.3. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг ТӨХ-д заана.</p> <p>1.4. Тендерт оролцогч багцтай тендер шалгаруулалтын хэдэн ч багцад тендер ирүүлж болно.</p> |
| <b>2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг</b> | <p>2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өргтгийг ТӨХ-д тусгана.</p>   |
| <b>3. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх</b> | <p>3.1. Захиалагч, тендерт оролцогч болон худалдан авах ажиллагаанд оролцогч аливаа этгээд холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.</p> <p>3.2. ТШЗ-ны 3.1-д заасан этгээдийн Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу нэн даруй мэдэгдэнэ.</p>  |
| <b>4. Тендерт оролцогч</b>                           | <p>4.1. Тендерт оролцогч нь захиалагчаас хараат бус этгээд байна.</p> <p>4.2. Хэд хэдэн этгээд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендер ирүүлэх бол тэдгээрийг хамтад нь түншлэл, тус бүрийг нь түншлэлийн гишүүн гэнэ.</p> <p>4.3. Хуулийн 9.3-т зааснаар гадаадын этгээдийг оролцохыг хориглосноос бусад тохиолдолд тендерт оролцогч болон түүний түншлэлийн гишүүн аль ч улсын харьяалалтай байж болно.</p> <p>4.4. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригтой хамаарах улсын этгээд тендерт оролцох эрхгүй.</p>  |

- 4.5. Тендерийн баримт бичгийн үнийг төлсөн, эсхүл үнэ төлбөргүй олгох тендерийн баримт бичгийг цахим системээр хүлээн авсан этгээдийг тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээд гэж үзнэ.
- 5. Туслан гүйцэтгүүлэх болон түншлэлийн гэрээ**
- 5.1. Тендерт оролцогч нэг ба түүнээс дээш тооны этгээдтэй туслан гүйцэтгүүлэх гэрээ байгуулж болно. Нийт туслан гүйцэтгүүлж болох бараа, ажил, үйлчилгээний дээд хэмжээ нь тендерийн үнийн 10 хувиас хэтрэхгүй байна.
- 5.2. Тендерийн дагуу ТШЗ-ны 4.2-т заасан түншлэлийн гишүүн тус бүрийн гүйцэтгэх үүргийн хэмжээ тендерийн үнийн 10 хувиас дээш байна.
- 5.3. Түншлэлийн гишүүн тус бүр холбогдох журмын дагуу цахим системээр түншлэлийг баталгаажуулснаар түншлэлийг нэг тендерт оролцогч гэж үзнэ. Түншлэлийн гишүүн гадаадын этгээд бол энэ зүйлд зааснаар баталгаажуулахгүй байж болно.
- 5.4. Түншлэлийн гэрээ нь дараах шаардлагыг хангасан байна:
- 5.4.1. Иргэний хуулийн 476 дугаар зүйлд заасан хамтран ажиллах гэрээний шаардлага хангасан байх;
- 5.4.2. ТШЗ-ны 1.2-т заасан ажил гүйцэтгүүлэхэд түншлэлийн бүх гишүүний хамтран болон тус тусдаа хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байх;
- 5.4.3. түншлэлийг төлөөлөн зааварчилгаа хүлээн авах, захиалагч болон бусад этгээдтэй харилцах, гомдол, нэхэмжлэл гаргахад төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилсон байх;
- 5.4.4. нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөр тооцоог зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй харилцаж, гүйцэтгэх тухай заасан байх.
- 5.5. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээг бичгээр байгуулсан, эсхүл хуульд нийцүүлэн тоон гарын үсгээр баталгаажуулсан байна.
- 5.6. Туслан гүйцэтгүүлэх гэрээнд заасан туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэх үүргийн хэмжээ ТШЗ-ны 5.1-ийг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
- 5.7. Түншлэлийн гэрээнд заасан түншлэлийн гишүүний гүйцэтгэх үүргийн хэмжээ ТШЗ-ны 5.2-ыг зөрчсөн бол захиалагч тухайн түншлэлийн гэрээ, түншлэлийн гишүүний чадавх, түүнд холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

- |   |   |
|---|---|
| <b>6. Тендерт оролцогч нэг тендер ирүүлэх</b> | <p>5.8. Түншлэлийн гишүүд болон туслан гүйцэтгэгчийн тоонд захиалагч хязгаарлалт тавихгүй.</p> <p>6.1. Аливаа этгээд дангаар, эсхүл түншлэлийн гишүүний хувиар тендер шалгаруулалтад оролцоход зөвхөн нэг тендер ирүүлнэ.</p> <p>6.2. Тендерт оролцогч, эсхүл түүний түншлэлийн гишүүн нь тендер шалгаруулалтын нэг багцад оролцож байгаа бусад тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүнтэй Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасан харилцан хамааралтай, эсхүл тэдгээрийн итгэмжлэлгүйгээр буюу итгэмжлэлээр төлөөлөх эрх бүхий этгээд нь нэг этгээд бол ТШЗ-ны 6.1-д заасныг зөрчсөн гэж үзнэ.</p> |
|---|---|

## **Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА**

- |   |   |
|---|---|
| <b>7. Тендерийн баримт бичиг</b>  | <p>7.1. Захиалагч баталсан тендерийн баримт бичгийг худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn/">/www.tender.gov.mn/</a> (цаашид “цахим систем” гэх)-ээр илгээн олон нийтэд нээлттэй байршуулна.</p> <p>7.2. Тендерийн урилгыг тендерийн баримт бичигтэй нийцүүлж боловсруулна.</p> <p>7.3. Тендерийн урилга тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.</p> <p>7.4. Тендерийн баримт бичиг нь дор дурдсан бүлэг болон ТШЗ-ны 10 дугаар зүйлд зааснаар түүнд оруулсан өөрчлөлтөөс бүрдэнэ:</p> <p style="margin-left: 20px;">I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;<br/>     II Бүлэг. Тендерийн өгөгдлийн хүснэгт;<br/>     III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;<br/>     IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;<br/>     V Бүлэг. Тендерийн жишиг маягт;<br/>     VI Бүлэг. Гэрээний нөхцөл.</p> <p>7.5. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендерийн баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.</p> <p>7.6. Тендерт оролцогч ТШЗ, ТӨХ-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, ажлын даалгавар, зураг төсөв, техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага болон тэдгээрт иш татсан хууль тогтоомж, журам, зааврыг судалж тендер бэлтгэнэ.</p> |
| <b>8. Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах</b> | <p>8.1. Тендерт оролцогч тендерийн баримт бичгийн талаар тодруулга, нэмэлт мэдээлэл авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг захиалагчид гаргаж болно.</p> <p>8.2. ТШЗ-ны 8.1-ийн дагуу гаргах хүсэлтийг бичгээр</p>   |

- захиалагчийн ТӨХ-д заасан хаягаар, эсхүл тоон гарын үсэг ашиглан цахим системээр захиалагчид хүргүүлнэ.
- 8.3. Тендерийн баримт бичгийн талаар тодруулга нэмэлт, мэдээлэл авах хүсэлтэй тендерт оролцогч энэ тухай хүсэлтэд тендерийн баримт бичгийн үнийг төлсөн (тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй авсан бол шаардлагагүй) баримтыг хавсаргана.
  - 8.4. Захиалагч тендерийн баримт бичгийн тодруулга, нэмэлт мэдээллийг холбогдох журмыг баримтлан цахим системд нийтэлснийг хуульд зааснаар бүх сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.
  - 8.5. Тодруулга, нэмэлт мэдээллийн дагуу тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч ТШЗ-ны 10-т заасны дагуу шийдвэрлэнэ.
- 9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**
- 9.1. Тендер бэлтгэх явцад үүсэж болох аливаа асуудлыг тодруулах, энэ талаар сонирхогч этгээдийн тавьсан асуултад хариулт өгөх зорилгоор захиалагч тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах бол ТӨХ-д заана. Захиалагч уулзалтад сонирхогч этгээд, эсхүл түүний томилсон төлөөлөгчийг оролцуулна.
- 9.2. ТШЗ-ны 9.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аливаа этгээдийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.
- 10. Тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах, тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгах**
- 10.1. Захиалагч ТШЗ-ны 24.1-д заасан хугацаанаас ажлын 10 хоногийн дотор тендерт оролцогчид тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг нэмэгдүүлэх өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулсан бол сонирхогч этгээд хуулийн 55.1-д зааснаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт гомдол гаргах боломжит хугацаагаар тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгана.
- 10.2. ТШЗ-ны 10.1-д зааснаас бусад тохиолдолд захиалагч тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулсантай холбоотойгоор сонирхогч этгээд өөрийн тендерт өөрчлөлт оруулах боломжит хугацаагаар тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгаж болно.
- 10.3. Тендерийн баримт бичгийн аливаа өөрчлөлт нь түүний салшгүй хэсэг болох бөгөөд холбогдох журмын дагуу цахим системд нийтэлснээр бүх сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.
- В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**
- 11. Тендер шалгаруулалтад оролцох зардал**
- 11.1. Тендер бэлтгэх, илгээх, оролцохтой холбогдон гарах бүх зардлыг сонирхогч этгээд болон тендерт оролцогч бүрэн хариуцна. Захиалагч энэ зардалтай холбогдох аливаа хариуцлага хүлээхгүй.

- 11.2. Сонирхогч этгээд гэрээний үүрэг гүйцэтгэх газар, орчны нөхцөл байдалтай танилцаж болох бөгөөд түүнтэй холбогдох зардлыг өөрөө хариуцна.
- 12. Тендериийн баримт бичиг болон тендериийн хэл**
- 12.1. Тендер шалгаруулалтын урилга, тендериийн баримт бичгийг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендериийн баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, тендерт оролцогчдын ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг зохих ёсоор орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.
- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг ТӨХ-д өөрөөр зааж болно.
- 12.3. Тендериийн баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендериийн баримт бичгийг баримтална.
- 12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба тендерт оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээдээр орчуулуулсан эсэхээс үл хамааран орчуулга үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.
- 13. Тендериийн иж бүрдэл**
- 13.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах баримт бичгээс бүрдэнэ:
- 13.1.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн тендер илгээх маягт;
- 13.1.2. тендер илгээх маягтыг тендерт оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
- 13.1.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
- 13.1.4. тендерт оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий нөхцөлийг хангасан болохыг нотлох баримт бичиг;
- 13.1.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт,

- шардлагыг хангахыг нотлох баримт бичиг;
- 13.1.6. санал болгож буй ажил ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан тендерийн баримт бичгийн шардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
- 13.1.7. ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан ажлын төсөв;
- 13.1.8. захиалагч шардсан бол ТШЗ-ны 22 дугаар зүйлд заасан тендерийн баталгаа;
- 13.1.9. түншлэл бол ТШЗ-ны 5.4-т заасан түншлэлийн гэрээ.
- 13.2. Тендерт оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
- 14. Тендерийн жишиг маягтууд**
- 14.1. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийн V бүлэг дэх маягтыг бөглөж ТШЗ-ны 23-т заасны дагуу илгээнэ. Маягтад өөрчлөлт оруулалгүй холбогдох хэсгийн мэдээллийг бөглөнө.
- 14.2. Тендерт оролцогч цахим системийн холбогдох талбарыг бөглөж тендер илгээнэ.
- 15. Хувилбарт санал**
- 15.1. ТӨХ-д тусгайлан заасан тохиолдолд тендерт оролцогч хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.
- 16. Ерөнхий нөхцөлийг магадлахад шардлагатай баримт бичиг**
- 16.1. Тендерт оролцогчтой холбоотойгоор хуулийн 14.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу хуульд заасан ерөнхий нөхцөлийг хангасан байна. Тендерт оролцогч нь ерөнхий нөхцөлийг хангасан тухай мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.
- 16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь дараах баримт бичгийг ирүүлнэ:
- 16.2.1. тендерт оролцогчийн сүүлийн 3 жилийн хугацаанд оролцсон иргэний хэрэг, маргааны талаар шүүхийн архивын байгууллагаас холбогдох дүрэм, журмын хүрээнд гаргасан тодорхойлолт;
- 16.2.2. тендерт оролцогчтой холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт.
- 16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:
- 16.3.1. гадаадын этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

- 16.3.2. тухайн улсын хууль тогтоомжийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлсөн болохыг нотлох баримт бичиг.
- 16.4. Захиалагч тендерт оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.2, 16.3-т заасан баримт бичгийг тендерт оролцогчоос шаардана. Түншлэлийн хувьд гишүүн тус бүр ерөнхий нөхцөлийг хангах тухай энэ зүйлд заасан баримт бичгийг ирүүлнэ.
- 17. Гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхыг магадлахад шаардлагатай баримт бичиг**
- 17.1. Захиалагч нь хуулийн 12.2-т зааснаар тендер шалгаруулалтад тавигдах санхүүгийн, техникийн чадавхын болон туршлагын хангавал зохих доод шалгуур үзүүлэлт, шаардлагыг тогтоож, тендерийн баримт бичигт тодорхой тусгана.
- 17.2. Тендерт оролцогч нь хуулийн 15 дугаар зүйлд зааснаар гэрээний үүргийн биелэлтийг хангах санхүүгийн чадавхын талаар захиалагчаас ТӨХ-д заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан байна. Энэхүү шалгуур үзүүлэлт, шаардлагыг нотлох дараах баримт бичгээс ТӨХ-д заасныг ирүүлнэ:
- 17.2.1. харилцагч банкны мэдэгдэл;
- 17.2.2. гадаадын этгээдийн хувьд ТШЗ-ны 17.3-т заасан хугацаанд хамаарах санхүүгийн тайлан;
- 17.2.3. ТШЗ-ны 17.3-т заасан тайлант хугацаанд хамаарах санхүүгийн тайландах холбогдох аудитын дүгнэлт;
- 17.2.4. ТШЗ-ны 17.3-т заасан санхүүгийн тайлангийн хугацаанд хэрэгжүүлсэн борлуулалтын орлогын талаарх мэдээлэл;
- 17.2.5. гэрээний үүргийн биелэлтийг хангах санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох ТӨХ-д заасан бусад баримт.
- 17.3. Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг ТӨХ-д заана.
- 17.4. Хууль тогтоомжоор санхүүгийн тайлангийн аудит хийлгэх үүрэг хүлээгээгүй этгээд нь ТШЗ-ны 17.2.3-т заасан аудитын дүгнэлт ирүүлэх шаардлагагүй.
- 17.5. Тендерт оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдэл болон тендерт оролцогчид зээлийн эрх үүсгэсэн, эсхүл зээлийн өр төлбөрийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг магадлахад

харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

- 17.6. Тендерт оролцогч нь хуулийн 16 дугаар зүйлд зааснаар гэрээний үүргийн биелэлтийг хангах техникийн чадавх болон туршлагын талаар захиалагчаас ТӨХ-д заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан байна. Энэхүү шалгуур үзүүлэлт, шаардлагыг нотлох дараах баримт бичгээс ТӨХ-д заасан баримт бичгийг ирүүлнэ:
  - 17.6.1. ажил гүйцэтгэхэд шаардлагатай ТӨХ-д заасан тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл;
  - 17.6.2. гэрээг хэрэгжүүлэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаарх ТӨХ-д шаардсан V бүлгийн Маягт 4-ийн дагуу бэлтгэсэн мэдээлэл;
  - 17.6.3. гэрээг хэрэгжүүлэхэд ашиглагдах ТӨХ-д заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл, тэдгээрийг цаг хугацаанд нь (өөрийн өмчлөл, эзэмшлийн, түрээслэх гэх мэт) бэлэн байлгах тухай Маягт 5-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл ;
  - 17.6.4. тендерт оролцгчийн туршлагыг харуулах ТӨХ-д заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн Маягт 6, Маягт 8-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл;
  - 17.6.5. техникийн чадавх болон туршлагын талаар ТШЗ-ны 17.6-д заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлох ТӨХ-д заасан бусад баримт.
- 17.7. ТӨХ-д шаардсан бол тендерт оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг V бүлгийн Маягт 7-ын дагуу ирүүлнэ. ТШЗ-ны 17.2, 17.6-д заасан чадавхыг магадлахад энэ мэдээллийг ашиглана.
- 17.8. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагын өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 17.9. Түншлэл нь ТШЗ-ны 17.2, 17.6-д заасан доод шалгуур үзүүлэлт, шаардлагыг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. ТШЗ-ны 17.2-т борлуулалтын орлого, гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ, ТШЗ-ны 17.6-д ижил төстэй гэрээний үнийн дүнгийн

- шалгуур үзүүлэлтийг тус тус заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- |   |  |
|---|--|
| <b>18. Санал болгож буй ажил тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг</b> | 18.1. Тендерт оролцогчийн санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.<br><br>18.2. Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.<br><br>18.3. III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага нь тухайн ажил гүйцэтгэхэд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.  |
| <b>19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт</b>   | 19.1. Тендерт оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.<br><br>19.2. Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх бүхий этгээдээр тооцуулж ирүүлнэ.<br><br>19.3. Тендер илгээх маягтад тусгасан үнэ нь үнийн хөнгөлөлтийг тооцоогүй тухайн тендерийн нийт үнэ байна.<br><br>19.4. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан тендер илгээх маягтад заана. Үнийн хөнгөлөлтийг хэрэглэх нөхцөл, аргачлалыг тусгайлан заагаагүй бол санал болгосон үнийн хөнгөлөлтийн хувь, хэмжээг тендерийн нийт үнээс тооцно.<br><br>19.5. Хууль болон ТӨХ-д өөрөөр заагаагүй бол тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. ТӨХ-д үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.<br><br>19.6. Ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын хувьд санал болгож буй үнэд барилга байгууламжийн ажил, барилгын тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажил, тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа нийлүүлэхтэй холбоотой тээвэрлэлтийн болон даатгалын зардал, татвар, хураамжийг тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд эдгээр зардлыг багтсанд тооцно. |

- 19.7. ТШЗ-ны 19.2-т заасан төсвийн нийт нийлбэр нь ТШЗ-ны 32 дугаар зүйлд заасан арифметик алдаагүй боловч ТШЗ-ны 19.3-т заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг тендерийн үнэ гэж үзнэ.
- 20. Тендерийн валют**
- 20.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол захиалагч тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 21. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 21.1. Тендерт оролцогч ТШЗ-ны 26 дугаар зүйлд заасны дагуу тендер нээснээс хойш хэд хоногийн хугацаанд өөрийн тендер хүчинтэй байхыг тендер илгээх маягтад заана. Тендерт оролцогч тендер хүчинтэй байх хугацааг заагаагүй, эсхүл 30-аас бага хоногоор тогтоосон бол тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ.
- 21.2. Эрх бүхий этгээдээс тендер шалгаруулалтын хүчинтэй байх хугацааг зогсоохоор шийдвэрлэсэн тохиолдолд захиалагч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлтийг бүх тендерт оролцогчдод хүргүүлнэ.
- 21.3. Хуулийн 29.4-т зааснаар тендерийн хүчинтэй байх хугацааг сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд захиалагч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлтийг бүх тендерт оролцогчдод хүргүүлнэ.
- 21.4. Тендерт оролцогч ТШЗ-ны 21.3-т заасан хүсэлтийн дагуу тендер хүчинтэй байх хугацааг сунгах эсэх мэдэгдлийг бичгээр болон цахим системээр тоон гарын үсэг ашиглан захиалагчид хүргүүлнэ.
- 21.5. Тендерт оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 22 дугаар зүйлд заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил сунгагдана.
- 21.6. Тендерт оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгахаас татгалзах эрхтэй. Хэрэв татгалзсан бол түүний тендерийн баталгааг улсын орлого болгох үндэслэл болохгүй.
- 21.7. Урьдчилсан худалдан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулж буй тендер шалгаруулалтад оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
- 22. Тендерийн баталгаа**
- 22.1. Захиалагч ТШЗ-ны 2.1-д заасан төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон тендерийн баталгаа ирүүлэхийг ТӨХД заана. Тендерт оролцогч тухайн үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй үүрэг гүйцэтгэх тухай тендерийн баталгааг холбогдох этгээдээр

гаргуулан ирүүлнэ.

- 22.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 22.1-д зааснаар ирүүлнэ.
- 22.3. Тендерийн баталгаа нь V бүлгийн 0-ын дагуу Монгол Улсын, эсхүл гадаадын банкны гаргасан баталгаа, эсхүл Маягт З-ын дагуу Засгийн газрын бонд, Засгийн газраас хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр байж болох ба ТШЗ-ны 14 дүгээр зүйлд зааснаар бэлтгэсэн байна.
- 22.4. Гадаадын хуулийн этгээд гадаадын банкны баталгаа гаргуулсан, гадаадын болон Монгол Улсын хуулийн этгээд гадаад улс дахь эрх бүхий этгээдээс Монгол Улсын Засгийн газрын бонд болон Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн бусад үнэт цаас хэлбэрээр тендерийн баталгаа гаргуулах бол дараах шаардлагыг хангасан байна:
  - 22.4.1. тендерийн баталгааны эх хувийг ТШЗ-ны 12 дугаар зүйлийг баримтлан бэлтгэсэн орчуулгын хамт холбогдох журамд зааснаар захиалагчид хүргүүлэх;
  - 22.4.2. баталгаа гаргагчийн нэрийн өмнөөс захиалагчтай харилцах, мэдэгдэл хүлээн авах эрх бүхий этгээдээр Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллага, бусад этгээдийг заасан байх.
- 22.5. ТШЗ-ны 22.4-т зааснаар гадаад улс дахь эрх бүхий этгээд баталгаа гаргаснаас бусад тохиолдолд тендерийн баталгааг холбогдох журамд зааснаар цахим системээр хүргүүлнэ.
- 22.6. Тендерийн баталгаа нь ТШЗ-ны 21 дүгээр зүйлд зааснаар тендерт оролцогчийн тогтоосон тендерийн хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 22.7. Тендер шалгаруулалтад шалгараагүй тендерт оролцогчийн тендерийн баталгааны ТШЗ-ны 22.6-д заасан хугацаа дууссан, эсхүл захиалагчийн гэрээ байгуулсан тухай мэдэгдэлд үндэслэн баталгаа гаргагч тус тендерийн баталгааг хүчингүй болгож болно.
- 22.8. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- 22.9. Захиалагч ТШЗ-ны 39 дүгээр зүйлд заасны дагуу гүйцэтгэлийн баталгаа хүлээн авч, ТШЗ-ны 40 дүгээр зүйлд заасны дагуу гэрээ байгуулсны дараа бүх оролцогчийн тендерийн баталгааг хүчингүй болгохыг зөвшөөрсөн мэдэгдэл гаргана. Уг мэдэгдлийг цахим

системээр баталгаа гаргагчид хүргүүлнэ.

- 22.10. Баталгаа гаргагч нь тендерийн баталгааг улсын орлого болгосон мөнгөн хөрөнгийг Төрийн сангийн холбогдох дансанд, Монгол Улсын Засгийн газрын бонд болон Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн бусад үнэт цаасыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэр дээр тус тус шилжүүлнэ.
- 22.11. ТШЗ-ны 21.6-д заасны дагуу тендерт оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгахаас татгалзсан бол захиалагч тухайн тендерээс татгалзаж, тендерийн баталгааг чөлөөлнө.

#### **Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**

##### **23. Тендер баталгаажуулах, илгээх**

- 23.1. Тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг баталгаажуулан тендер шалгаруулалтад илгээнэ. Үүсгэн байгуулагдсан улсын хууль тогтоомжоор шаардаагүй бол тамга, тэмдэг дараахгүй байж болно.
- 23.2. ТШЗ-ны 23.1-д заасны дагуу итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд баталгаажуулсан тохиолдолд итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.
- 23.3. Хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээс итгэмжлэлээр эрх олгогдсон этгээд нь өөрийн гарын үсэг, эсхүл тоон гарын үсгээр тендерийг баталгаажуулсан байна.
- 23.4. Тендерт оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 23.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
- 23.5. Тендерт оролцогч өөрийн тендерийн дараах баримт бичгээс бусад хэсгийг зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэлээр нууцалж болно:
  - 23.5.1.ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасны дагуу ирүүлсэн бүх баримт бичиг;
  - 23.5.2.V бүлгийн дагуу ирүүлсэн маягт;
  - 23.5.3.санал болгож буй ажил техникийн тодорхойлолтод нийцэх эсэхийг ТШЗ-ны 18.2-т зааснаар тайлбарласан тайлбар;
  - 23.5.4.ТӨХ-д заасан бусад баримт бичиг.
- 23.6. Тендерт оролцогч ТШЗ-ны 23.7-д зааснаас бусад тохиолдолд тендерийг бүхэлд нь бусад тендерт оролцогчдод ил болгохыг хүлээн зөвшөөрч илгээнэ.

- 23.7. Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг V бүлгийн Маягт 9-ийн дагуу нууцлахгүйгээр ируулнэ..
- 24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 24.1. Тендерт оролцогч тендериийг ТӨХ-д заасан огноо, цагаас өмнө холбогдох журмын дагуу цахим системээр илгээнэ. Тендер хүлээн авах эцсийн хугацааг цахим системийн цагаар тооцно.
- 25. Тендерт өөрчлөлт оруулах, тендериийг буцааж авах**
- 25.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тендерт нэмэлт, өөрчлөлт оруулах, солих, эсхүл түүнийг буцаан авах эрхтэй.
- 25.2. Тендер хүлээн авах эцсийн хугацаа өнгөрснөөс хойш тендерт аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах, түүнийг солих, эсхүл буцааж авахыг зөвшөөрөхгүй ба холбогдох журмын дагуу захиалагч архивын нэгж үүсгэн хадгална.
- 25.3. Тендерт оролцогч илгээсэн тендэрээсээ тендериийн нээлтээс хойш татгалзах хүсэлтэй бол энэ тухай захиалагчид албан бичгээр мэдэгдэнэ.
- 26. Тендер нээх**
- 26.1. Захиалагч тендериийн нээлтийг цахим системээр ТӨХ-д заасан огноо, цагт, заасан газарт зохион байгуулна.
- 26.2. ТШЗ-ны 26.1-д заасан газар зохион байгуулж буй тендериийн нээлтэд тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцах эрхтэй. Нээлтэд биечлэн оролцсон этгээд тендериийн нээлтийн тэмдэглэлд гарын үсэг зурна.
- 26.3. Тендериийг нээх үед дараах мэдээлэл бүхий тэмдэглэлийг цахим системд байршуулна:
- 26.3.1. тендерт оролцогчийн нэр;
  - 26.3.2. тендериийн үнэ;
  - 26.3.3. санал болгосон бол үнийн хөнгөлөлт;
  - 26.3.4. хувилбарт санал ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд хувилбарт саналын үнэ;
  - 26.3.5. тендериийн баталгаа ирүүлсэн эсэх.
- 26.4. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол нээлтийн тэмдэглэлийг багц тус бүрээр үйлдэнэ.
- 26.5. Доор дурдсанаас бусад тохиолдолд тендериийн нээлтэд зарлагдаагүй буюу тэмдэглэлд заагаагүй үнэ, үнийн хөнгөлөлтийг үнэлгээнд харгалзахгүй:
- 26.5.1. ТШЗ-ны 19.7-д зааснаар эрх бүхий этгээдийн тооцсон төсвийн нийт нийлбэрийг тендериийн

үнэ гэж үзэх;

26.5.2. ТШЗ-ны 31 дүгээр зүйлд зааснаар тендерийн үнийг нэг валютад хөрвүүлэх;

26.5.3. ТШЗ-ны 32 дугаар зүйлд зааснаар тендерийн үнийн арифметик алдааг запруулах.

#### Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ

##### 27. Нууцлах

27.1. Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх болон үнэлгээний дүгнэлттэй холбогдсон мэдээллийг тендер шалгаруулалтын үр дүн гарах хүртэлх хугацаанд тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй этгээд болон тендерт оролцогчдод задруулахгүй.

27.2. Тендерийг “хамгийн сайн” гэж үнэлсэн бол тендер илгээх маягтад дурдсанаар түүний нууцлаагүй хэсгийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгоно.

##### 28. Тендерийн талаар тайлбар, тодруулга авах

28.1. Захиалагч тендерт оролцгчийн ирүүлсэн тендер, эсхүл цахим системээр илгээсэн мэдээлэл ойлгомжгүй, тодорхойгүй, зөрчилдөөнтэй гэж үзвэл зөвхөн уг асуудлыг тодруулах, тайлбар авах зорилгоор энэ зүйлд заасны дагуу тодруулга ирүүлэхийг тендерт оролцгчоос шаардах, эсхүл холбогдох бусад этгээдээс энэ тухай лавлагаа авах хүсэлт гаргаж болно.

28.2. ТШЗ-ны 28.1-д заасан тайлбар, тодруулгыг авахад талууд албан бичгээр харилцана.

28.3. Тендерт оролцогч захиалагчтай харилцах албан бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулж цахим системээр илгээж болно. Энэ тохиолдолд тендер шалгаруулалтын хавтаст хэрэгт хадгална.

28.4. ТШЗ-ны 32 дугаар зүйлийн дагуу хийсэн арифметик алдааны запруулгыг хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд тендерт оролцгчийг тендерийн агуулга, үнэд аливаа өөрчлөлт оруулахыг санал болгохгүй.

28.5. ТШЗ-ны 28.1-д зааснаар тайлбар, тодруулга авах, эсхүл хуульд заасан үндэслэлээр тендерт оролцгчтой хэлэлцээ хийхээс бусад тохиолдолд захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хорооны гишүүд тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл тендерт оролцогч, түүний төлөөлөгчтэй ямар нэгэн уулзалт зохион байгуулахгүй, шууд болон шууд бусаар холбоо тогтоохгүй.

##### 29. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг

29.1. Тендерийг ТШЗ-ны 13 дугаар зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, тендерт оролцогч болон түүний тендерийн талаар

## **ХЯНАН ҮЗЭХ**

авсан тайлбар, тодруулгад үндэслэн дараах шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан үзнэ:

- 29.1.1. тендерт оролцогчийн харьялал ТШЗ-ны 4 дүгээр зүйлд заасан шаардлагыг зөрчөөгүй байх;
  - 29.1.2. тендерт оролцогч, түүний туслан гүйцэтгэгч болон түншлэл ТШЗ-ны 4 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байх;
  - 29.1.3. ТШЗ-ны 6 дугаар зүйлд зааснаар зөвхөн нэг тендер ирүүлсэн байх;
  - 29.1.4. V бүлэг дэх маягтын дагуу ирүүлсэн баримт бичиг нь холбогдох шаардлага хангасан байх;
  - 29.1.5. ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасны дагуу хянан үзэхэд тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүнтэй холбоотойгоор хуулийн 14.1-д заасан нөхцөл тогтоогдоогүй байх;
  - 29.1.6. ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасны дагуу хянан үзэхэд тендерт оролцогч нь санхүүгийн, техникийн чадавхын болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан байх;
  - 29.1.7. ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасны дагуу хянан үзэхэд санал болгож буй ажил нь тендерийн баримт бичгийн шаардлагад нийцэж байх;
  - 29.1.8. ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэхэд холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативын дагуу өртгийн төсвийг тооцсон байх;
  - 29.1.9. захиалагчийн тогтоосон эсхүл холбогдох гэрээний нөхцөлөөр тодорхойлогдсон талуудын хүлээх эрх, үүргийг зөвшөөрсөн байх;
  - 29.1.10.тендерийн баримт бичигт тавигдсан бусад шаардлагад нийцсэн байх.
- 29.2. Захиалагч тендерийн дараах зөрүүг жижиг хэмжээний зөрүү гэж үзэж болно:
    - 29.2.1. ТШЗ-ны 29.1.7-д заасны дагуу хянан үзэхэд санал болгосон ажил нь техникийн тодорхойлолтоос зөрүүтэй байгаа нь гүйцэтгүүлэх ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээргүй;
    - 29.2.2. ТШЗ-ны 29.1.9-д зааснаар хянан үзэхэд тендерт санал болгосон гэрээний нөхцөл нь захиалагч баталсан тендерийн баримт бичиг дэх гэрээний нөхцөлөөс зөрүүтэй байгаа нь захиалагчийн эрх, тендерт оролцогчийн үүрэгт тендерийн

		баримт бичигтэй үл нийцэх хязгаарлалт оруулаагүй.
29.3.	Хэрэв захиалагч ТШЗ-ны 29.2-т заасан жижиг хэмжээний зөрүүг хүлээн зөвшөөрөх нь шаардлагад нийцсэн бусад тендерийн өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөхгүй бол тус тендерийг шаардлага хангасан гэж үзнэ.	
29.4.	Захиалагч IV бүлэгт жижиг хэмжээний зөрүүг залруулах аргачлалыг тусгаж болно.	
29.5.	Захиалагч ТШЗ-ны 29.3-т зааснаар жижиг хэмжээний зөрүүг хүлээн зөвшөөрч, тендерийг шаардлага хангасан гэж үзсэн бол тендерийн үнийг ТШЗ-ны 29.4-т заасан аргачлалын дагуу хийсвэрээр нэмэгдүүлнэ.	
29.6.	Шаардлагад нийцсэн тендер гэж ТШЗ-ны 29 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэхэд тендерийн баримт бичгийн бүх нөхцөл, шаардлагыг буюу ТШЗ-ны 3-6, 11-24 дүгээр зүйлүүдэд заасан шаардлагыг нэгэн зэрэг хангаж байгаа, түүнд заасан баримт бичиг, тендер илгээх маягт болон бусад маягтуудыг зохих ёсоор ирүүлсэн, маягтуудын агуулгад өөрчлөлт оруулаагүй тендерийг хэлнэ.	
29.7.	ТШЗ-ны 29.6-д зааснаас бусад тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж, уг тендерээс татгалзана.	
29.8.	Захиалагч нь ТШЗ-ны 29.7-д зааснаар тендерээс татгалзахдаа тендерт оролцогч нь ТШЗ-ны 16.1, 17.4, 17.5-д тендерт оролцогчоос шаардахгүй тухай тусгайлан заасан баримт бичгийг ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн гэж тендерээс татгалзахгүй.	
<b>30. Тендерийг үнэлэх</b>	<b>30.1.</b> Захиалагч зөвхөн ТШЗ-ны 29.6-д заасан шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн тендерийг хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.	
	<b>30.2.</b> Хэрэв ТӨХ-д заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт болон холбогдох бусад хууль тогтоомжид зааснаар үнэлнэ.	
<b>31. Нэг валютад хөрвүүлэх</b>	<b>31.1.</b> Тендерийн үнэ болон төсөвт заасан үнийг ТШЗ-ны 20 дугаар зүйлд зааснаас өөр валютаар илэрхийлсэн тохиолдолд тендерийг үнэлэхэд тендер шалгаруулалт зарласан өдрийн Монгол банкны албан ханшийг үндэслэн тендерийн үнийг ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан валютад хөрвүүлнэ.	
<b>32. Арифметик алдааг залруулах</b>	<b>32.1.</b> Шаардлагад нийцсэн гэж үнэлсэн тендерийн үнийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:	
	32.1.1. нэг төрлийн зардлын нэгж үнийг тоо ширхгээр үржүүлэхэд гарсан дүнгээс тухайн мөр дэх нийт зардлын дүн зөрвөл нэгж үнийг үндэслэн түүний мөр дэх нийт зардлын дүнг залруулна.	

- Харин нэгж үнийн бүхэл болон бутархай орны цэгийг алдсан нь илэрхий гэж үзвэл тухайн зардлын мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна;
- 32.1.2. мөр дэх үнийн нийлбэр эсхүл ялгаварт алдаа байвал мөр дэх үнийг үндэслэн нийт үнийг залруулна;
- 32.1.3. тоо болон үгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэж тоон дүнг залруулна. Харин үгээр илэрхийлсэн дүн нь арифметик алдаанаас шалтгаалсан бол ТШЗ-ны 32.1.1, 32.1.2-т нийцүүлэн тоогоор илэрхийлсэн дүнг баримтална.
- 32.2. ТШЗ-ны 32.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг тендерт оролцогчид хүргүүлнэ.
- 33. Тендерт оролцогчид давуу эрх олгох**
- 33.1. Хуулийн 10 дугаар зүйлийн дагуу тендерт оролцогч давуу эрх тооцуулах нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Давуу эрх олгох бол санал болгож буй үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 33.2. ТШЗ-ны 33.1-т заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй ба энэ нь тухайн тендерт оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 34. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 34.1. Тендерийн харьцуулах үнийг дараах дарааллаар үнэлнэ:
- 34.1.1. ТШЗ-ны 19 дүгээр зүйлд зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;
- 34.1.2. ТШЗ-ны 32.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;
- 34.1.3. ТШЗ-ны 19.4-т заасны дагуу санал болгосон үнийн хөнгөлөлт тооцох;
- 34.1.4. ТШЗ-ны 34.1.1-34.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 31 дүгээр зүйлд зааснаар нэг валютад хөрвүүлэх;
- 34.1.5. ТШЗ-ны 33 дугаар зүйлд зааснаар давуу эрх олгох;
- 34.1.6. ТШЗ-ны 30.2-т заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.
- 34.2. Тендерийн үнийг залруулсан, үнийн хөнгөлөлт тооцсон, нэг валютад хөрвүүлсний дараах үнэ төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн бол хуулийн

- 30.1.3-ыг үндэслэн уг тендерээс татгалзана.
- 34.3. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцоходоо дараах аргачлалыг баримтална:
- 34.3.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг ТШЗ-ны 34.1-д заасны дагуу сонгох;
- 34.3.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 36.2-т зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;
- 34.3.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.
- 34.4. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.
- 34.5. ТШЗ-ны 34.4-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 35. Тендерийг харьцуулах, хэлэлцээ хийх**
- 35.1. Захиалагч “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг сонгохдоо хуулийн 28.7.3-т заасны дагуу тендерүүдийг эрэмбэлж, хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгоно.
- 35.2. Хуульд заасан үндэслэлээр тендерт оролцогчтой хэлэлцээ хийх тохиолдолд хэлэлцээний үр дүнд түүний тендерийн захиалагчийн тавьсан шаардлага, шалгуур үзүүлэлт, ажлын тоо хэмжээнд үл хамаарах хэсэгт өөрчлөлт оруулахыг зөвшөөрнө.
- 36. Тендерт оролцогчийн чадавхыг дахин магадлах**
- 36.1. Захиалагч хэд хэдэн багцад “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадалж болно.

- 36.2. ТШЗ-ны 36.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 36.3. Хэрэв тендерт оролцогчийг хэд хэдэн багцад гэрээ байгуулахад шаардлага хангахгүй гэж магадалсан бол түүний гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлагыг хангах нэг, эсхүл түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх олгоно.
- 36.4. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхыг дахин магадалж шаардлага хангахгүй гэж үзвэл уг тендерээс татгалзана. Энэ тохиолдолд удаах хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзэж, оролцогчийн чадавхыг мөн адил зарчмаар магадална.

#### **Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

- 37. Мэдэгдэл хүргүүлэх** 37.1. Захиалагч дараах мэдэгдлийн аль тохирохыг тендерт оролцогч тус бүрд бичгээр хүргүүлж, тухайн өдөрт багтаан цахим системд байршуулна:
- 37.1.1. “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгох;
  - 37.1.2. ТШЗ-ны 37.1.1-т зааснаас бусад шаардлага хангасан тендер ирүүлсэн оролцогчид шалгараагүй тухай мэдэгдэх;
  - 37.1.3. ТШЗ-ны 29.7, 34.2-т заасан тендерээс татгалзах.
- 37.2. Захиалагч гэрээ байгуулах эрх олгосон бол энэ тухай шийдвэр, мэдэгдэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг холбогдох журмын дагуу ил болгох тухай ТШЗ-ны 37.1.2, 37.1.3-т заасан мэдэгдэлд дурдана.
